



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



2026 IV

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ





**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС**

САРЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 4 дүгээр сар

**Улаанбаатар хот
2026 он**

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2022-2026 он	7
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	7
I.	Нийгмийн даатгал, халамж	8
II.	Эрүүл мэнд	14
III.	Гэмт хэрэг	17
IV.	Төсөв	26
V.	Хэрэглээний үнэ	29
VI.	Аж үйлдвэр	34
VII.	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	39

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин их
- 1/X** дахин бага
- 0.0 маш бага тоо
- | харьцуулагдахгүй
- 0.0° тэнцүү/ өөрчлөлтгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.


IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



МЭДЭЭЛЭЛ

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрүм	=10 ⁹
их аяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
ккал	калори
Гкал	килокалори
с	гигакалори(=10 ⁹ калори)
мин	секунд
мкг/м ³	минут
м/с	микрограмм метр куб
ш	метр секунд
х.д.х	ширхэг
	хэвлэлийн даралтат
	хуудас



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

ХҮСНЭГТ 1. БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 I-IV	2023 IV	2024 IV	2025 IV	2026 IV	
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	1 208 ↓23.8	1 328 ↑9.9	1 106 ↓16.7	1 042 ↓5.8	987 ↓5.3	
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	22 797 ↑751.0	636 ↓97.2	741 ↓16.5	887 ↑19.7	863 ↓2.7	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	2 053 ↑271.0	1 735 ↓15.6	1 780 ↑2.8	2 277 ↑27.9	2 385 ↑4.7	
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)	Хувь	2.9 ↓0.5	1.4 ↓51.7	0.6 ↓57.1	0.3 ↓50.0	3.0 ↑9.0**	
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	3 042 ↑6.7	3 496 ↑14.9	3 377 ↓3.4	3 542 ↑4.9	3 574 ↑0.9
	Юань (БНХАУ)	Төгрөг	473 ↑8.2	508 ↑7.4	466 ↓8.3	485 ↑4.1	523 ↑7.8
	Рубль (ОХУ)	Төгрөг	38 ↑13.2	43 ↑13.2	36 ↓16.3	43 ↑19.4	47 ↑9.3
Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	29.9 ↓22.7	55.8 ↑86.6	84.4 ↑51.3	91.8 ↑8.8	108.8 ↑18.5	
Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	30.7 ↑2.7	48.9 ↑59.3	74.3 ↑51.9	94.2 ↑26.8	99.4 ↑5.5	
Агаарын дундаж температур	°C	3.4	0.0	4.9	4.7	3.7	

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 I-IV						2026 I-IV					
		Хотын дундаж		Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж		Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	357	Баянгол	8 797	Налайх	59	357	Баянгол	8 797	Налайх	59		
			Чингэлтэй	1 490	Багануур	47		Чингэлтэй	1 490	Багануур	47		
			Сүхбаатар	688	Багахангай	32		Сүхбаатар	688	Багахангай	32		
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	16	Багануур	29	Баянзүрх	10	15	Багануур	37	Хан-Уул	9		
			Сүхбаатар	17	Чингэлтэй	9		Налайх	23	Баянгол	6		
			Налайх	18	Багахангай	-		Сүхбаатар	14	Багахангай	-		
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	43	Багануур	42	Хан-Уул	26	50	Багануур	49	Сүхбаатар	31		
			Баянзүрх	39	Налайх	18		Баянзүрх	48	Налайх	25		
			Баянгол	34	Багахангай	13		Чингэлтэй	38	Багахангай	5		
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	83	Баянзүрх	123	Баянгол	91	77	Баянзүрх	191	Налайх	86		
			Сүхбаатар	121	Багахангай	80		Хан-Уул	175	Багахангай	58		
			Хан-Уул	120	Багануур	26		Чингэлтэй	119	Багануур	25		
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	119	Сүхбаатар	200	Сонгино-хайрхан	78	125	Сүхбаатар	213	Багануур	69		
			Чингэлтэй	140	Налайх	41		Чингэлтэй	175	Багахангай	45		
			Баянгол	133	Багахангай	29		Баянгол	142	Налайх	40		



НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын орлого өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар, нийгмийн даатгалын зарлага 15.9 хувиар тус тус өссөн байна.


2026 оны 4 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын 5 төрлийн санд нийт 179.5 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.6 (15.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ЖИЛ БҮРИЙН 4 ДҮГЭЭР САРД

Үзүүлэлт	2025 IV	2026 IV	<u>2026 IV</u> <u>2025 IV</u>
	сая төгрөг		хувь
Нийт орлого	166 819.8	196 603.2	17.9
Тэтгэврийн даатгалын сангийн	138 479.6	162 910.4	17.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	14 751.7	17 430.5	18.2
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сангийн	8 419.7	10 184.8	21.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	5 168.8	6 077.5	17.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	-	-	-
Нийт зарлага	154 856.7	179 478.3	15.9
Тэтгэврийн даатгалын сангийн	138 192.2	157 327.1	13.8
Тэтгэмжийн даатгалын сангийн	8 227.1	10 188.0	23.8
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сангийн	879.8	959.6	9.1
Ажилгүйдлийн даатгалын сангийн	7 557.6	11 003.6	45.6

¹-Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин


ЗУРАГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРД



Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 82.9 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 5.2 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 8.9 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 3.0 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

ЗУРАГ 2.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, 2026 оны 4 дүгээр сард



Нийгмийн даатгалын сангаас 2026 оны 4 дүгээр сарын байдлаар даатгуулагч иргэдэд 179.5 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардал зарцуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.6 (15.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зардлын 87.7 хувийг тэтгэврийн, 0.5 хувийг ҮОМШӨ-ний, 5.7 хувийг тэтгэмжийн, 6.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 4 дүгээр сард

Үзүүлэлт	Тэтгэвэр, тэтгэмж авагчид			Олгосон тэтгэвэр, тэтгэмж		
	2025 IV	2026 IV	<u>2026 IV</u> 2025 IV	2025 IV	2026 IV	<u>2026 IV</u> 2025 IV
	тоо		хувь	сая төгрөг		хувь
Сангийн нийт зарлага	152 483	43 014	-63.6	154 856.7	179 478.3	17.1
Тэтгэврийн даатгалын сан	142 135	36 082	-74.6	138 192.2	157 327.1	13.8
Өндөр насны	114 013	29 124	-74.5	118 372.2	128 734.0	8.8
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр	15 779	3 758	-76.2	7 894.0	11 294.0	43.1
Тэжээгчээ алдсаны	4 806	1 239	-74.2	2 448.2	3 777.8	54.3
Цэргийн тэтгэвэр	7 537	1 961	-74.0	9 469.7	13 513.1	42.7
Бусад зардал	-	-	-	8.1	8.3	2.5
Тэтгэмжийн даатгалын сан	6 061	4 761	-21.4	8 227.1	10 188.0	23.8
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	4 474	3 173	-29.1	1 947.0	1 617.2	-16.9
Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	1 320	1 262	-4.4	5 745.9	7 525.2	31.0
Оршуулгын тэтгэмж	267	326	22.1	534.0	979.5	83.4
Бусад зардал	-	-	-	0.2	66.0	3.3**
ҮОМШӨ¹-ний даатгалын сан	828	251	-69.7	879.8	959.6	9.1
Тахир дутуугийн тэтгэмж	606	144	-76.2	675.5	649.5	-3.8
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	98	25	-74.5	99.1	125.9	27.0
Тэтгэмж, төлбөр	124	81	-34.7	104.3	161.4	54.7
ҮОМШӨ ¹ -ний сувилал	-	1	-	0.6	0.1	-83.3
Бусад зардал	-	-	-	0.3	22.7	7.5**
Ажилгүйдлийн даатгалын сан	3 459	1 920	-44.5	7 557.6	11 003.6	45.6
Ажилгүйдлийн тэтгэмж	3 459	1 920	-44.5	7 557.6	11 003.6	45.6


Нийгмийн даатгал

2026 оны 4 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 43014 иргэнд 179478 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгогдсоны 36082 иргэнд 157327 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 4761 иргэнд 10188 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас, 1920

иргэнд 11004 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас, 251 иргэнд 960 сая төгрөгийг үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тус тус зарцуулсан байна.

ЗУРАГ 3.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧДЫН ТОО, ЖИЛ БҮРИЙН 4 ДҮГЭЭР САРД



2026 оны 4 дүгээр сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 43014 иргэнд 179.5 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгогдсоны 80.7 хувийг өндөр настны, 10.4 хувийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 3.4 хувийг тэжээгчээ алдсаны, 5.5

хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна. Тэтгэвэр авагчдийн 80.7 хувийг өндөр настны тэтгэвэр эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 848899 (74.5%) иргэнээр буурсан бол 10.4 (8.8%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн зарлага өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өссөн байна.

Нийгмийн халамж нь орлого багатай, хүүхэд, өндөр настан зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн арга хэрэгсэл юм. Нийгмийн халамжийн сангаас 2026 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 491.1 мянган иргэнд 59216.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдож, өнгөрсөн оны мөн үеэс 1586 (2.8%) иргэнээр, 3083.3 (5.5%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 38413.6 (64.9%) сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж, 5349.2 (9.0%) сая төгрөгийг нийгмийн

халамжийн тэтгэвэрт, 6090.9 (10.3%) сая төгрөгийг асаргааны тэтгэмж, 1816.9 (3.1%) сая төгрөгийг эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж, үлдсэн 7545.8 (12.7%) сая төгрөгийг онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж, ахмад настны тэтгэмж хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж болон бусад тусламж тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 4 дүгээр сард

Үзүүлэлт	2025 IV		2026 IV		2026 IV 2025 IV
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	хувь
	тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг	
Нийт олгогдсон тэтгэвэр, тэтгэмж	489 560	56 133.1	491 146	59 216.4	5.5
Тэтгэвэр	11 017	4 313.7	11 881	5 349.2	24.0
Асаргааны тэтгэмж	17 636	5 088.8	18 576	6 090.9	19.7
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	35 624	1 897.7	32 391	1 816.9	-4.3
Алдарт эхийн одонгийн тусламж	12 212	2 869.3	12 834	2 995.5	4.4
Алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж	33	11.3	28	10.3	-8.8
Хүүхдийн мөнгө	384 564	38 456.4	384 136	38 413.6	-0.1
Насны хишиг	14 791	1 184.8	16 373	1 295.9	9.4
Онцгой тохиолдолын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	4	4.8	14	14.4	2.0**
Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт	-	-	-	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж	-	-	-	-	-
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	7 911	1 822.2	8 613	2 397.9	31.6
Бусад	5 768	484.1	6 300	831.8	71.8

Энэ оны 4 дүгээр сарын байдлаар 2732 ахмадад 628.8 сая төгрөгийн ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт зарцуулагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 696 (34.2%) хүн, 274.4 (77.4%) сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АХМАД НАСТНЫ ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН 4 ДҮГЭЭР САРД

Үзүүлэлт	2025 IV		2026 IV		2026 IV 2025 IV
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	хувь
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	
Бүгд	2 036	354 351.5	2 732	628 766.7	77.4
Оршуулгын тэтгэмж	14	28 000.0	3	8 000.0	-71.4
Амралт, сувилал	226	58 365.0	341	88 195.0	51.1
Рашаан, сувилал	933	141 331.5	1 228	324 785.7	1.3**
Протез	743	94 827.0	834	108 590.0	14.5
Ортопед, тусгай хэрэгсэл	118	31 548.0	314	97 516.0	2.1**
Ахмадын хүндэтгэл	-	-	-	-	-
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	2	280.0	12	1 680.0	5.0**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулан харвал хүний тоо 267 (17.3%), олгосон тэтгэмж 80.5 (83.9%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖ, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН 4 ДҮГЭЭР САРД

Үзүүлэлт	2025 IV		2026 IV		2026 IV 2025 IV
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	хувь
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	
Бүгд	1 539	95 909.8	1 806	176 385.7	83.9
Харилцаа, холбооны зардлын хөнгөлөлт	1 331	26 421.1	1 335	26 649.0	0.9
Оршуулгын тэтгэмж	15	30 000.0	10	30 000.0	-
Цэцэрлэг сургуулийн унааны зардал	24	4 800.0	20	4 000.0	-16.7
Рашаан сувилал	40	9 308.7	49	19 081.0	1.1**
Протез	37	7 560.0	55	8 420.0	11.4
Ортопед тусгай хэрэгсэл	32	9 420.0	296	82 495.6	7.7**
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	60	8 400.0	41	5 740.0	-31.7
Бусад	-	-	-	-	-

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт, тусламж авсан нийт хүний дийлэнх буюу 73.9 хувийг харилцааны холбооны зардлын хөнгөлөлт авсан иргэд эзэлж байгаа боловч

олгосон тэтгэмж нь 15.1 хувь байна. Харин ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, тусламж авсан иргэдийн мөнгөн дүн 46.8 буюу хамгийн их хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Нийгмийн халамж: Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Байнгын асаргаа шаардлагатай иргэн: Бусдын тусалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ.

Бүтэн өнчин хүүхэд: Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх/эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.

Өрх толгойлсон эх /эцэг/: Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хэлнэ.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ: Асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа хэлнэ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ: Иргэн, аж ахуйн нэгж, төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг тусалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

Эх үүсвэр:

Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн сарын мэдээ

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн сарын мэдээ



ЭРҮҮЛ МЭНД

2026 оны 4 сард 1 032 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 60 (5.8%) төрөлтөөр буурсан байна.

Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний 4 сард 972 эх амаржиж, 987 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 60 (5.8%), мэндэлсэн хүүхэд өмнөх оны мөн үеэс 55 (5.3%) хүүхдээр

тус тус буурсан байна. Амьгүй төрөлтийн 3 тохиолдол бүртгэгджээ. Нийт амаржсан эхчүүдийн дунд гэртээ төрсөн тохиолдол бүртэгдээгүй байна.


ХҮСНЭГТ 8. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 4 САРД

Үзүүлэлт	2024 IV	2025 IV	2026 IV	Өөрчлөлт %
Амаржсан эхийн тоо	1 096	1 032	972	-5.8
Гэрийн төрөлт	1	1	-	-
Хяналтгүй төрөлт	4	4	3	-25.0
Амьгүй төрөлт	4	1	3	3**
Амьд төрсөн хүүхэд	1 106	1 042	987	-5.3
Эхийн эндэгдэл	-	1	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	13	11	6	-45.5
1-5 настай хүүхдийн эндэгдэл	3	1	-	-
Нас барсан хүн	316	302	313	3.6

2026 оны эхний 4 сард 0-1 хүртэл насандаа эндсэн 6 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 5 (45.5%-аар буурсан байгаа бол 1-5 настай хүүхдийн эндэгдэл бүргэгдээгүй эерэг үзүүлэлттэй байна.

Дүүргийн хэмжээнд нас баралт 313 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 11 (3.6%) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



Дүүрэгт 2026 оны эхний 4 сарын байдлаар 863 халдварт өвчин бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 24 (2.7%) тохиолдлоор буурсан байна. Цочмог халдварт өвчний 31.0 хувийг салхин

цэцэг, 3.6 хувийг улаан эсэргэнэ, 24.7 хувийг энтервируст цэврүүт фарингит, 7.6 хувийг улаан бурхан, 33.1 хувийг цусан суулга, ёлом, гепатит, сальмонеллэз зэрэг өвчин тус тус эзлээд байна.

ХҮСНЭГТ 9. ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн 4 дүгээр сард

Төрөл	Хэмжих нэгж	2024 IV	2025 IV	2026 IV	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	тоо	741	887	863	-24	-2.7
	10000 хүнд	12.3	14.1	33.7	19.6	
Вируст гепатит	тоо	7	8	3	-5	-62.5
	10000 хүнд	0.3	0.2	0.1	0.1	
Цусан суулга	тоо	28	37	20	-17	-45.9
	10000 хүнд	1.1	1.4	0.8	-0.6	
Сальмонеллөз	тоо	9	10	8	-2	-20.0
	10000 хүнд	0.4	0.2	0.3	-0.1	
Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга өвчин	тоо	-	5	1	-4	-80.0
	10000 хүнд	-	0.2	-	-0.2	
Хоолны хордлого	тоо	-	34	9	-25	-73.5
	10000 хүнд	0.1	1.3	0.4	-0.9	
Энтервируст халдвар тодорхойгүй/ВЗ4.1/	тоо	-	-	52	52	-
	10000 хүнд	-	-	2.0	-2.0	
Салхинцэцэг	тоо	268	260	204	-56	-21.5
	10000 хүнд	10.7	10.1	8.0	-2.1	
Гахай хавдар	тоо	21	2	4	2	100.0
	10000 хүнд	0.8	0.1	0.2	0.1	
Улаан эсэргэнэ	тоо	44	22	24	2	9.1
	10000 хүнд	1.8	0.86	0.94	0.08	
Ёлом	тоо	4	6	5	-1	-16.7
	10000 хүнд	0.2	0.2	0.2	-	
Бруцеллөз	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	
Менингококкт халдвар	тоо	-	1	2	1	100.0
	10000 хүнд	-	-	0.1	0.1	
Энтервируст тууралттай цэврүүт фарингит	тоо	53	37	163	126	4.4**
	10000 хүнд	2.1	1.4	6.4	5.0	
Эритема	тоо	-	31	17	-14	-45.2
	10000 хүнд	-	1.2	0.7	-0.5	
Улаан бурхан	тоо	-	189	50	-139	-73.5
	10000 хүнд	-	7.4	2.0	5.4	
Хачигт рикеттсиоз	тоо	-	-	3	3	-
	10000 хүнд	-	-	0.1	0.1	
Бусад халдварт өвчин	тоо	-	-	94	94	-
	10000 хүнд	-	-	3.7	3.7	
Тэмбүү	тоо	150	99	100	1	1.0
	10000 хүнд	6.0	3.9	3.9	-	
Гонококкт халдвар	тоо	43	48	21	-27	-56.3
	10000 хүнд	1.7	1.9	0.8	-1.1	
Трихомониаз	тоо	36	26	30	4	15.4
	10000 хүнд	1.4	0.8	1.2	0.4	
Сүрьеэ	тоо	78	72	52	-20	-27.8
	10000 хүнд	3.1	2.8	2.0	-0.8	

Төрөл	Хэмжих нэгж	2024 IV	2025 IV	2026 IV	Өөрчлөлт	
					тоо/нэгж хувь	хувь
ДОХ	тоо	-	-	-	-	-
	10000 хүнд	-	-	-	-	-
Мөөгөнцөр	тоо	-	-	1	1	100.0
	10000 хүнд	-	-	-	-	-

Өнгөрсөн оны мөн үеэс гоногокт халдвар 27 (56.3%) тохиолдлоор буурсан эерэг үзүүлэлттэй байна. 10.0 мянган хүн тутмын 3.9 нь тэмбүү өвчнөөр өвчилж байна.

Баянгол дүүрэгт 2026 оны эхний 4 сард 659 хүн цочмог халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 17 (2.6%) хүнээр өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

(1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин

Эх үүсвэр:
Дүүргийн Эрүүл мэндийн төвийн сарын мэдээ



ГЭМТ ХЭРЭГ

Баянгол дүүрэгт 2385 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 108 (4.7%) хэргээр өссөн байна.

2026 оны 4 сард 2385 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 108 (4.7%) хэргээр өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 48.8 хувьтай байгаа нь 33.8 нэгж хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 2213 иргэн хохирч, 24.3 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 3.6 тэрбум (14.9%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 50.7 хувийг залилан, 12.4 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 16.3 хувийг хулгайн, 2.5 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.1 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг, 2.5 хувийг дээрмийн, 1.0 хувийг хүчин, 0.3 хувийг хүнийг санаатай алах, 13.2 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.


ХҮСНЭГТ 10. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн 4 дүгээр сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2024 IV	2025 IV	2026 IV	Тоо	Хувь
Нийт гэмт хэрэг	1 780	2 277	2385	108	4.7
Хүнийг санаатай алах	10	5	8	3	60.0
Хүний амьд явах эрхийн эсрэг	44	41	26	-15	-36.6
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	311	367	295	-72	-19.6
Хүчиндэх	13	30	23	-7	-23.3
Хулгайлах	374	547	389	-158	-28.9
Дээрэмдэх	41	70	59	-11	-15.7
Залилан	661	794	1 209	415	52.3
Танхайрах	2	2	1	-1	-50.0
ХАБТХАЖЭ	21	63	60	-3	-4.8
Бусад гэмт хэрэг	305	358	315	-43	-12.0

Өнгөрсөн оны мөн үеэс дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг өссөн сөрөг үзүүлэлтэд хүнийг санаатай алах 3 (60.0%), залилан 415 (52.3%) тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин үний амьд явах эрхийн эсрэг 15 (36.6%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг

72 (19.6%), хүчиндэх 7 (23.3%), хулгайлах 158 (28.9%), дээрэмдэх 11 (15.7%), танхайрах 1 (50.0%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 3 (4.8%), бусад гэмт хэрэг 43 (12.0%) нэгж хэргээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 5.

БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2026 оны 4 дүгээр сард

Бүртгэгдсэн хулгайн гэмт хэргийн 301 (77.4%) нь иргэдийн өмчийн, 65 (16.7%) нь халаасны, 5 (1.3%) нь авто тээврийн хэрэгсэл, 18 (4.6%) нь бусад хулгайн гэмт хэрэг тус тус эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс авто тээврийн хэрэгслийн хулгай хамгийн их буюу 68.8 хувь буурсан байна.

Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилдаг болсон. 2026 оны 4 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 2224 (93.2%) нь хөнгөн хэрэг, 161 (6.8%) нь хүнд хэрэг байна.

ХҮСНЭГТ 11.


БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, хэлтсээр, 2026 оны 4 дүгээр сард

Төрөл		Бүгд		
		Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс	Тоо
Нийт гэмт хэрэг		2 385	1 154	1 231
Хэргийн ангилал	Хөнгөн	2 224	1 066	1 158
	Хүнд	161	88	73
Гэмт хэргийн төрөл	Хүнийг алах	8	5	3
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	26	16	10
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	295	147	148
	Хүчиндэх	23	16	7
	Хулгайлах	389	182	207
	○ Иргэдийн өмчийн	301	139	162
	○ Авто тээврийн хэрэгслийн	5	3	2
	○ Халаасны	65	33	32
	○ Бусад	18	7	11
	Дээрэмдэх	59	29	30
	Залилах	1209	548	661
	Танхайрах	1	1	-
	ХАБТХАЖЭ ²	60	33	27
	Бусад	315	177	138

Нийт бүртгэгдсэн 2385 гэмт хэргээс 1154 (48.4%) нь цагдаагийн I хэлтэст, 1231 (51.6%) нь цагдаагийн II хэлтэст гарч, өнгөрсөн оны мөн үеэс I хэлтэст 137 (10.6%) хэргээр буурсан эерэг үзүүлэлтэй байгаа бол II хэлтэст 245 (24.8%) хэргээр өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 133 (84.8%) нь согтуугаар, 165 (2.2 дахин их) нь бүлэглэн, 452 (2.6 дахин их) нь эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг байна.


ЗУРАГ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн цаг, гарагаар, жил бүрийн 4 дүгээр сард



Энэ оны 4 дүгээр сарын байдлаар даваа, пүрэв, баасан гаригт хамгийн их буюу 1089 (54.3%) гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн хамгийн их үйлдэгдсэн нь даваа гарагийн 06:00-14:00 цагийн хооронд байна.

Дүүргийн хэмжээнд 2026 оны 4 дүгээр сарын байдлаар гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн газар болох гэр, орон сууцанд 886 (23.6%) хэрэг, гудамж талбайд 639 (22.6%) хэрэг, олон нийтийн газарт 448 (14.8%) хэрэг, бусад үйлдэгдсэн газар 412 (2.3 дахин их) тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, жил бүрийн 4 дүгээр сард



Гэмт хэргийн гаралтыг хороо тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34-р хороо 54 (70.1) хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байгаа бол бусад хороодод 10.1 хувиас 5.4 дахин их хувиар өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Дүүргийн долоодугаар хорооны нутаг дэвсгэрт 277 (5.4 дахин их) гэмт хэргийн бүртгэгдсэн нь хамгийн их байсан бол хамгийн бага нь 3, 6, 16, 17, 23, 29 дүгээр хороодод бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 12. НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, хороо, төрлөөр, 2026 оны 4 дүгээр сард

Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэндийн халдашгүй	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	Танхайрах	ХАБТХАЖЭ ²	Бусад
	Тоо										
Бүгд	2 385	8	26	295	23	389	59	1 209	1	60	315
I хороо	109	-	-	7	1	11	3	47	-	3	37
II хороо	188	-	1	4	-	22	1	143	-	2	15
III хороо	73	-	1	7	-	5	-	39	-	2	19
IV хороо	76	1	1	11	-	14	3	20	-	3	23
V хороо	71	-	3	13	1	20	1	21	-	4	8
VI хороо	109	-	-	13	-	18	2	56	-	5	15
VII хороо	328	-	1	13	-	10	3	289	-	1	11
VIII хороо	54	1	-	17	-	10	1	19	-	1	5
IX хороо	63	-	1	11	1	22	2	18	-	2	6
X хороо	40	-	2	6	2	7	1	13	-	1	8
XI хороо	142	-	2	12	2	13	-	92	-	3	18
XII хороо	45	-	2	7	2	6	1	18	-	1	8
XIII хороо	111	-	1	13	-	22	4	56	-	4	11
XIV хороо	82	-	1	19	1	25	3	21	-	1	11
XV хороо	40	-	-	2	1	7	1	21	-	1	7
XVI хороо	77	1	1	12	-	13	3	35	1	1	10
XVII хороо	73	1	-	15	4	14	4	21	-	2	12
XVIII хороо	59	-	1	7	-	8	-	24	-	5	14
XIX хороо	46	1	1	10	-	9	2	16	-	1	6
XX хороо	87	1	1	13	-	16	2	40	-	3	11
XXI хороо	28	-	-	4	-	5	2	12	-	-	5
XXII хороо	38	-	2	12	3	2	5	7	-	2	5
XXIII хороо	24	1	1	4	1	4	2	5	-	4	2
XXIV хороо	55	-	1	9	-	16	1	24	-	-	4
XXV хороо	38	-	-	9	1	3	-	14	-	-	11
XXVI хороо	56	1	1	8	1	13	-	24	-	3	5
XXVII хороо	29	-	-	5	-	7	-	15	-	-	2
XXVIII хороо	30	-	-	1	-	9	2	17	-	-	1
XXIX хороо	88	-	-	11	1	20	5	37	-	1	13
XXX хороо	15	-	-	2	-	3	-	8	-	-	2

Гэмт хэрэг

Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэндийн халдашгүй	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	Танхайрах	ХАБТХАЖЭ ²	Бусад
	Тоо										
XXXI хороо	33	-	-	3	-	10	2	15	-	1	2
XXXII хороо	31	-	-	3	1	11	-	11	-	1	4
XXXIII хороо	24	-	1	3	-	7	3	7	-	1	2
XXXIV хороо	23	-	-	9	-	7	-	4	-	1	2


Бүртгэгдсэн зөрчил:

Дүүргийн нутаг дэвсгэрт энэ оны 4 дүгээр сарын байдлаар 12658 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1633 (11.4%) хэргээр буурч, зөрчил гаргасан 12124 иргэн, хуулийн

этгээдийг 527.7 сая төгрөгөөр торгосон бол 223 хүнийг “Зөрчлийн тухай” хуулиар баривчилжээ.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 48.2 хувь нь I хэлтэст, 51.8 хувь нь II хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 8. БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, хэлтсээр, жил бүрийн 4 дүгээр сард




Нийт илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлт, илрүүлэлтийн хувийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад II хэлтэст 1739 (21.0%) хэргээр буурсан бол I хэлтэст 106 (1.8%) хэргээр өссөн байна. Нийт илрүүлсэн зөрчлийг нийслэлийн 9 дүүргийн хэлтсүүдтэй харьцуулахад Баянгол дүүргийн цагдаагийн II хэлтэст зургаадугаарт, I хэлтэст долдугаарт эрэмбэлэгдэж байна.

2026 оны 4 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн нийт зөрчлийн 1506 (11.9%) нь даваа, 1996 (15.8%) нь мягмар, 1825 (14.4%) нь лхагва, 2053 (16.2%) нь пүрэв, 1934 (15.3%) нь баасан, 1888 (14.9%) нь бямба, 1456 (11.5%) нь ням гарагуудад тус тус үйлдэгдсэн байна.

ХҮСНЭГТ 13. НИЙТ БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, үйлдэгдсэн гарагаар, 2026 оны 4 дүгээр сард

Үзүүлэлт	Бүгд	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
	Тоо							
Нийт	12 658	1 506	1 996	1 825	2 053	1 934	1 888	1 456
I хэлтэс	6 103	777	843	895	996	886	867	839
II хэлтэс	6 555	729	1 153	930	1 057	1 048	1 021	617

I хэлтэст бүртгэгдсэн нийт зөрчлийн 996 (16.3%) хэрэг нь пүрэв гарагт, II хэлтэст бүртгэгдсэн зөрчлийн 1153 (17.6%) хэрэг нь мягмар гарагт гарсан нь хамгийн их хувийг эзэлж байна.

ЗУРАГ 9. НИЙТ БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, үйлдэгдсэн цагаар, 2026 оны 4 дүгээр сард

Харин үйлдэгдсэн цагаар харвал 13.00-18.00 цагийн хооронд 2902 (31.0%) хэрэг зөрчил бүртгэгдсэн нь хамгийн их байгаа бөгөөд 06.00-12.00 цагийн хооронд 2250 (24.1%), 19.00-24.00 цагийн хооронд 2386 (25.5%), 01.00-05.00 цагийн хооронд 1815 (19.4%) зөрчил тус тус бүртгэгдээд байна.

Зөрчлийн улмаас хохирсон:


1052 иргэний 709 (67.3%) нь эмэгтэй, 104 (9.9%) 0-17 насны, 218 (20.7%) нь 18-29 насны, 292 (27.8%) нь 30-39 насны, 253 (24.0%) нь 40-49 насны, 114 (10.8%) нь 50-59 насны, 48

(4.6%) нь 60-69 насны, 23 (2.2%) нь 70-аас дээш насны ахмадууд байна. Хохирсон иргэдийн дийлэнх буюу 558 (53.0%) иргэн нь ажилгүй иргэд байна.

Зөрчил гаргасан:

1779 иргэний 540 (31.5%) нь эмэгтэй, насаар нь авч үзэхэд 30-44 орчим насны иргэд илүү зөрчил гаргаж байна.

ЗУРАГ 10. БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, боловсролын түвшин, 2026 оны 4 дүгээр сард




Зөрчил гаргасан иргэдийн 543 (30.5%) нь дээд, 46 (2.6%) нь тусгай мэргэжлийн, 1140 (64.0%) нь бүрэн дунд, 1 (0.1%) нь техникийн болон мэргэжлийн, 41 (2.3%) нь суурь, 5 (0.3%) нь бага, 3 (0.2%) нь боловсролгүй хүмүүс эзэлж байна.

Нийт зөрчил гаргагчдыг нийгмийн байдлаас нь үзвэл төрийн албан хаагч 23 (1.3%), хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 149 (8.4%), төрийн бус байгууллагын ажилтан 13 (0.7%), хувиараа хөдөлмөр эрхлэгч 393 (22.1%), оюутан 6 (0.3%), ажилчин, малчин 7 (0.4%), сурагч 7 (0.4%), ажилгүй 1078 (60.7%), бусад 100 (5.7%) иргэд тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл:

Дүүргийн хэмжээнд 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 7366 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 4000 (54.3%) нь гэмт хэргийн шинжтэй, 3366 (45.7%) нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл ирсэн байна.

ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ, шалган шийдвэрлэсэн байдлаар, 2026 оны 4 дүгээр сард




Гэмт хэргийн шинжтэй 5038 гомдол мэдээллийн 4439 (89.0%) хэргийг шийдвэрлэснээс 1701 (38.3%) нь хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн, 2566 (57.9%) нь хэрэг нээхээс татгалзсан, 172 (3.8%) нь харьяаллын дагуу шилжүүлэн хэргийг шийдвэрлэсэн байна. Нийт шийдвэрлэсэн 4439 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг 5 хоногт 634 (14.2%) хэргийг, 6-19 хоногт 3805 (85.7%) хэргийг

тус тус шийдвэрлэн ажиллажээ. Нийт шалган шийдвэрлэгдсэн зөрчлийн шинжтэй 4330 гомдол мэдээллийн 4185 (96.7%) хэргийг шийдвэрлэснээс 7945 (46.4%) хэрэгт зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, 2225 (53.1%) хэргийг нь зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан, 15 (0.4%) хэргийг нь харьяаллын дагуу шилжүүлсэн байна.

Зам тээврийн осол, зөрчил:

2026 оны 4 дүгээр сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт ослын шинжтэй 1728 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 174 (9.1%) дуудлагаар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 12. БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, дүүргээр, 2026 оны 4 дүгээр сард



Улаанбаатар хотод нийтдээ 1663 зам тээврийн осол бүртгэгдсний 547 (32.9%) нь Баянзүрх, 292 (17.6%) нь Хан-Уул, 236 (14.5%) нь Сонгинохайрхан, 237 (14.3%) нь Баянгол, 236 (14.2%) нь Сүхбаатар, 83 (5.0%) нь Чингэлтэй, 20 (1.2%) нь Налайх, 2 (0.1%) нь Багахангай, 3 (0.2%) нь Багануур дүүргүүдэд байна.

Бүртгэгдсэн ослыг дүүргийн хэмжээнд өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан авч 2.5 хувиар, эд материалын хохиролтой осол 7.1 хувиар өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 14. БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, төрлөөр, жил бүрийн эхний 4 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	<u>2026 I-IV</u> <u>2025 I-IV</u>
	Тоо			хувь
Нийт	1 210	1 623	1 663	2.5
Эд материалын хохиролтой осол	1 089	1 396	1 495	7.1
Хүн гэмтсэн осол	121	227	168	-26.0


Нийт зам тээврийн осол 1663 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 40 (2.5%) өссөн байна. Нийт бүртгэгдсэн зам тээврийн ослын 99 (89.9%) нь эд материалын хохиролтой осол өссөн бол хүн гэмтсэн осол 59 (10.1%) буурсан байна. 2026 оны 4 дүгээр сарын байдлаар зам

тээврийн ослын улмаас нийт 60 хүн бэртэж үүнээс хүн нас барсан 2 тохиолдол бүртгэгдсэн байна. Зам тээврийн ослын улмаас бэртсэн иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирсон иргэн 23 (96.7%) буурсан эерэг өөрчлөлттэй байна.


ХҮСНЭГТ 15. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС БЭРТСЭН ИРГЭД, төрлөөр, жил бүрийн эхний 4 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	<u>2026 I-IV</u> <u>2025 I-IV</u>
	Тоо			хувь
Нийт хохирсон иргэд	135	111	80	-27.9
Хүн гэмтсэн	133	110	79	-28.2
Хүн нас барсан	2	1	4	3.0**

ЗУРАГ 13.

БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, хэлбэрээр, тээврийн хэрэгслийн төрлөөр, дүнд эзлэх хувь, 2026 оны эхний 4 дүгээр сарын байдлаар

Нийт гэмтсэн хүний 1 (50.0%) хувийг явган зорчигч, 1 (50.0%) хувийг зорчигч тус тус эзэлж байна. Бүртгэгдсэн зам тээврийн ослын 211 (89.0%) нь мөргөлдсөн, 8 (3.4%) нь явган хүн дайрсан, 16 (6.8%) нь үл хөдлөх зүйл мөргөсөн байна. Зам тээврийн ослыг тээврийн хэрэгслийн төрлөөр нь 191 (80.6%) нь суудлын,



19 (8.0%) нь ачааны, 8 (3.4%) нь автобус, 1 (0.4%) микроавтобус, 7 (3.0%) нь мотоцикл, 4 (1.6%) нь унадаг дугуй, 7 (3.0%) нь бусад эзэлж байна. Оны 4 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн зам тээврийн ослын 1610 (67.7%) хэргийг даатгалд шилжүүлж, 645 (27.1%) хэрэгт акт тавьж, 124 (5.2%) хэргийн өргөдлийг хүлээн авсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр:

Дүүргийн Цагдаагийн I, II хэлтсийн сарын мэдээ



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Баянгол дүүргийн төсвийн нийт орлого 108.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 21.6 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн төсвийн нийт орлого 2026 оны эхний 4 сарын байдлаар 108798.1 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 21599 (16.6%) тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 96.0 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн татвар, бусад татвар, төлбөр,

хураамж), 4.0 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна.

Татварын орлогын дүнд хувь хүний орлогын албан татварын шилжүүлэг хамгийн өндөр буюу 94539.2 (86.9%) тэрбум төгрөгийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 16. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны эхний 4 дүгээр сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
	сая төгрөг		хувь
Нийт орлого	130 397.0	108 798.1	-16.6
1.Татварын орлого	128 408.2	104 485.8	-18.6
1.1 Орлогын албан татвар	119 225.0	94 539.2	-20.7
Хувь хүний орлогын албан татвар	119 225.0	94 539.3	-20.7
